

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН 2025

Prepared by:

ДУМ АУДИТ ХХК

Prepared for:

**Албан журмын даатгагчдын
холбоо ГҮТББ**

info@dumaudit.mn

+976 99085151



501 5TH FLOOR, BAKULA RINPOCHE STREET
CHINGELTEI DISTRICT, ULAANBAATAR
MONGOLIA
T + 976 11325262
T + 976 99085151

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

“Албан журмын даатгагчдын холбоо” ГҮТББ-н удирдлагад

Дүгнэлт

“Албан журмын даатгагчдын холбоо” ГҮТББ (“Холбоо”)-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Жижиг дунд аж ахуй нэгжийн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дүрэм, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Төлөөний газраас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Холбооны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Холбооны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Холбооны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Холбооны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.



Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Холбооны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Холбооны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Холбооны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад

Холбооны удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэлд захирлууд ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэлд агуулагдсан мэдээллүүд орох бөгөөд тусдаа санхүүгийн тайлан болон энэхүү аудиторын дүгнэлт орохгүй.

Энэхүү тусдаа санхүүгийн тайланд өгсөн манай аудиторын дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Тусдаа санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй бөгөөд бусад мэдээлэл нь тусдаа санхүүгийн тайлан эсвэл аудитын ажлын хүрээнд олж мэдсэн мэдээллээс материаллагаар зөрүүтэй эсвэл зөрүүтэй мэт харагдаж байгаа эсэхийг авч үзэх ёстой. Хэрэв бид хийсэн ажил дээрээ үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг алдаатай байна гэж үзвэл бодит мэдээллийг тайлагнах үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор ямар нэгэн тайлагнах зүйл байгаагүй болно.

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол улсын Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйл, Аудитын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 213 дугаар тогтоолын дагуу гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Дундманхайдай аудит ХХК



Б. Цэвэлмаа, Удирдах партнер

Монгол улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,
Бакула ринбүүчи гудамж,
Оршил оффис, 501 тоот

Огноо: 2026 оны 3 дүгээр сарын 10

“АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО” ГҮТББ-Н

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
ЖИЛИЙН АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН АУДИТЛАГДСАН
ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	2024-12-31 Төгрөгөөр	2025-12-31 Төгрөгөөр
Үндсэн үйл ажиллагааны орлого			
Жолоочийн даатгалын сангийн эх үүсвэр	3	2,708,171,518.18	3,060,026,913.42
Үйл ажиллагааны орлогын дүн		2,708,171,518.18	3,060,026,913.42
Ерөнхий ба удирдлагын зардал	4	1,295,589,425.55	1,417,115,261.95
Бусад зардал	5	509,786,389.27	613,847,822.28
Орлогын татварын зардал	5	184,697,573.54	182,984,215.35
Үйл ажиллагааны нийт зардал		1,990,073,388.36	2,213,947,299.58
Үндсэн үйл ажиллагааны үр дүн		718,098,129.82	846,079,613.84
Туслах, үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг/алдагдал	6	(6,948,702.77)	3,041,070.73
Тайлант үеийн цэвэр үр дүн		711,149,427.05	849,120,684.57

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн саллигүй нэг хэсэг болно.

“АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО” ГҮТББ-Н

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

Балансын зүйл	Тод	2024-12-31 Төгрөгөөр	2025-12-31 Төгрөгөөр
Хөрөнгө			
Эргэлтийн бус			
Үндсэн хөрөнгө	8	1,586,369,834.32	1,520,022,219.66
Биет бус хөрөнгө	7	89,586,286.50	-
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө		118,649,000.00	-
		1,794,605,120.82	1,520,022,219.66
Эргэлтийн			
Дансны ба бусад авлага	9	6,466,119,877.36	6,710,382,286.38
Найдваргүй авлагын хасагдуулга	9	(81,075,597.00)	(66,259,762.00)
Богино хугацаат хөрөнгө оруулалт	10	12,138,646,096.57	12,500,000,000.00
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	11	3,945,201.00	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12	197,246,178.43	704,780,784.21
Нийт эргэлтийн хөрөнгийн дүн		18,724,881,756.36	19,848,903,308.59
Нийт хөрөнгө		20,519,486,877.18	21,368,925,528.25
Эздийн өмч ба өр төлбөр			
Эздийн өмч			
Цэвэр хөрөнгө			
Нөөц: хязгаарлалтгүй	15	10,000,000.00	10,000,000.00
хязгаарлалттай		20,477,955,161.7	21,324,034,775.50
Цэвэр хөрөнгө өмчийн бусад хэсэг		5,864,268.5	8,905,339.25
		20,493,819,430.18	21,342,940,114.75
Богино хугацаат өр төлбөр			
Дансны болон бусад өр төлбөр	12	3,121,533.18	25,666,113.50
Бусад татварын өр төлбөр	13	22,545,913.82	319,300.00
		25,667,447.00	25,985,413.50
Урт хугацаат өр төлбөр			
Бусад урт хугацаат өр төлбөр	14	-	-
Нийт өр төлбөрийн дүн		25,667,447.00	25,985,413.50
Нийт эздийн өмч ба өр төлбөр		20,519,486,877.18	21,368,925,528.25

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн саллигүй нэг хэсэг болно.

“АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО” ГҮТББ-Н

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Хязгаарлалтгүй нөөц	Хязгаарлалттай нөөц	Цэвэр хөрөнгө өмчийн бусад хэсэг	Нийт өмч
	Төгрөгөөр	Төгрөгөөр	Төгрөгөөр	Төгрөгөөр
2024 оны 1-р сарын 1-ний байдлаар	10,000,000.00	20,477,955,161.66	5,864,268.52	20,493,819,430.18
Өмчийн өөрчлөлт				
Тайлант үеийн ашиг				
Ногдол ашиг				
2024 оны 12-р сарын 31-ны байдлаар	10,000,000.00	20,477,955,161.66	5,864,268.52	20,493,819,430.18
Өмчийн өөрчлөлт/залруулга				
Тайлант үеийн ашиг		846,079,613.84	3,041,070.73	849,120,684.57
Ногдол ашиг				
2025 оны 12-р сарын 31-ны байдлаар	10,000,000.00	21,324,034,775.50	8,905,339.25	21,342,940,114.75

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн саллигүй нэг хэсэг болно.

“АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО” ГҮТББ-Н

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2024-12-31 Төгрөгөөр	2025-12-31 Төгрөгөөр
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Гишүүдийн татвараас орсон мөнгө	17,000,000.00	36,000,000.00
Даатгалын сангийн орлого	640,387,438.55	1,100,012,839.99
Мөнгөн орлогын дүн	657,387,438.55	1,136,012,839.99
Ажиллагсад төлсөн	490,006,760.60	485,813,915.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	118,958,439.05	145,859,563.23
Ашиглалтын зардалд төлсөн	42,723,878.75	50,134,681.17
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	941,524,320.56	865,594,251.48
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	118,311,950.00	9,640,960.00
Татварын байгууллагад төлсөн	241,838,181.17	242,468,129.19
Даатгалын төлбөрт төлсөн	106,149,400.00	111,020,020.00
Бусад мөнгөн зарлага		
Мөнгөн зарлагын дүн	2,059,512,930.13	1,910,531,520.07
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,402,125,491.58)	(774,518,680.08)
Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого	18,031,244.00	30,000.00
Мөнгөн орлогын дүн	18,031,244.00	30,000.00
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	59,813,700.00	23,878,800.00
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	280,421,944.40	361,353,903.43
Мөнгөн зарлагын дүн	340,235,644.40	385,232,703.43
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(322,204,400.35)	(385,202,703.43)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хүү ба урамшууллын орлого	1,846,975,885.01	1,667,255,989.29
Мөнгөн орлогын дүн	1,846,975,885.01	1,667,255,989.29
Мөнгөн зарлагын дүн		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,846,975,885.01	1,667,255,989.29
Валютын ханшийн зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	122,645,993.08	507,534,605.78
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	74,600,185.35	197,246,178.43
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	197,246,178.43	704,780,784.21

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.